**ОНЦГОЙ БАЙДЛЫН УДИРДЛАГА**

# ГАМШГИЙН ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Ц.Бямбарагчаа. Доктор /Ph.D/,
дэд профессор

**Хураангуй:** Тамшгаас урьдчилан сэргийлэх" гэж аюулт үзэгдэл, ослын хор уршиг, хохирол, сөрөг үр дагавраас зайлсхийх, таслан зогсоох, бууруулах зорилгоор авч хэрэгжүүлж байгаа цогц арга хэмжээг хэлнэ.

**Түлхүүр үг:** Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, гамшгийн эрсдэл

## УДИРТГАЛ

Монгол Улс нь хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, хортон шавьж, мэрэгч тархах зэрэг олон төрлийн гамшигт өртөх эрсдэлтэй орнуудын нэг юм. 2021 оны 09 сарын байдлаар Монгол орон дахь гамшигт үзэгдэл 315,377 бүртгэгдэж 19,2 тэрбум төгрөгний хохирол учирсан статистик тоо баримт байна.

Гамшгийн менежментэд баримталж ирсэн уламжлалаар бол гамшиг болсон тохиолдолд хор уршгийг арилгах, сэргээн босгох, нэрвэгдэгсдэд туслалцаа үзүүлэх асуудалд голлон анхаарлаа хандуулдаг байсан бол орчин үед болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлаа сайжруулах, ард иргэдийн аюулгүй амьдрах талаарх мэдлэг боловсролыг нэмэгдүүлэх тал дээр илүүтэй анхаарах болсон. Ялангуяа тухайн газар оронд түгээмэл тохиолддог болон тохиолдож болзошгүй гамшгийн аюулаас ард иргэд өөрсдийгөө хамгаалах, тэмцэх, харилцан бие биедээ туслах, тэрхүү нөхцөл байдалд дасан зохицох асуудал нэн чухлаар тавигдах болсон юм. Иймээс гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны өнөөгийн түвшинд үнэлэлт дүгнэлт өгөх, урьдчилан сэргийлэх ажлыг цаашид хэрхэн үр дүнтэй, шинэлэг хэлбэрээр

шинжлэх ухааны үндэслэлтэйгээр зохион байгуулан явуулах арга замыг тодорхойлох нь чухал юм.

"ГАМШИГ" гэж “аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол” хэмээн Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуульд тодорхойлжээ. Энд багтсан “аюулт үзэгдэл” гэсэнд “хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, нуранги, хөрсний гулгалт үүсэх, гал түймэр, хүн, мал, амьны гоц халдварт өвчин гарах, цар тахал, хортон шавж, мэрэгч тархах” гэсэн зүйлүүдийг хамааруулж ойлгоно.

Монгол оронд тохиолдож буй байгалийн аюулт үзэгдэл, үйлдвэрлэл технологийн ослын тоо төрөл давтамж, цар хүрээ, учруулж буй хохирол жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа. Түгээмэл тохиолдож буй ган, зуд, үер ус, цөлжилт, газар хөдлөлт, хүн малын гоц халдварт өвчин гэх мэт 15 төрлийн байгалийн аюулт үзэгдэл манай оронд их тохиолддог.

Өнөөдөр аюулт үзэгдэл, ослын хор уршиг, хохирол, сөрөг үр дагавраас зайлсхийх, таслан зогсоох, бууруулах зорилгоор гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь юу юунаас чухал болоод байна.

**Зураг 1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны бүдүүвч**



Гамшгийн өмнөх үйл ажиллагаа нь урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тулгуурлах бөгөөд дараахь төрөлтэйгээр хэрэгжиж байна.

- гамшгийн эрсдэлийг үнэлэх;
- гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх;
- гамшгийн эрсдэлийг бууруулах;
- гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах;
- гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх;
- гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаа зохион байгуулах, мэдээллээр хангах;
- гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх.

Ард иргэдийн амь нас, эрүүл мэнд, амьжиргаа, улс орны соёлын өв, нийгэм, эдийн засгийн үнэт зүйл, экосистемийг илүү үр дүнтэй хамгаалахын тулд гамшгийн эрсдэлийг урьдчилан мэдэрч, төлөвлөлттэйгөөр бууруулах замаар гамшигтай тэмцэх чадавхиа бэхжүүлэх нь нэн чухал, яаралтай хэрэгжүүлэх асуудал юм. Тэгвэл **гамшгийн эрсдэл** гэдгийг гамшгийн улмаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд учирч болзошгүй хохиролын магадлалыг хэлнэ гэж ойлгож болно. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр гамшгийн давтамж, эрчим нэмэгдэж байна. Бүх л улс орны ард иргэд, эд хөрөнгийн гамшигт өртөх байдал нь эмзэг байдал буурахаас илүү хурдтай нэмэгдэж, гамшгийн шинэ эрсдэлийг бий болгохоос гадна, нийгэм, эдийн засаг, эрүүл мэнд, соёл, хүрээлэн буй орчинд богино, дунд, урт хугацаанд ноцтой нөлөөлөн ялангуяа орон нутаг, олон нийтийн түвшинд гамшгийн хохирол улам бүр нэмэгдэж байгааг тоо баримт харуулж байна.

Монгол Улс орны хувьд гамшигт хамгийн ихээр өртөгдөж, гамшгийн улмаас учирч буй хохирлын хэмжээ жилээс жилд нэмэгдэж байгаад дараах хүчин зүйлс нөлөөлж байна гэж үзэж байна. Үүнд

- Ядуурал, тэгш бус байдал
- Уур амьсгалын өөрчлөлт, цаг агаарын тогтворгүй байдал
- Төлөвлөлтгүй, хурдацтай явагдаж буй хотжилт, оновчгүй газар ашиглалт
- Хүн ам зүйн өөрчлөлт

- Хууль, эрх зүйн зохицуулалт сул, эрсдэлийг тооцоогүй бодлого
- Гамшгийн эрсдэлийг бууруулах хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг зохицуулах, урамшуулах механизм дутагдалтай
- Байгалийн нөөцийн ашиглалт тогтворгүй, экосистемийн доройтол
- Нийгмийн үйлчилгээ авах боломж хязгаарлагдмал газарт иргэд таруу суурьшсан

Гамшиг нь юуны өмнө хөгжилд, ялангуяа дэлхийн хамгийн ядуу, дорой улс орны болон хамгийн зах хязгаарт амьдардаг хүмүүсийн хөгжилд их аюул занал учруулдаг. Гамшигт ядуус илүү өртдөг бөгөөд гамшиг тэдний ядуу байгаа шалтгааны нэг болдог байгаа ба гамшгийн аюулын улмаас үүсэх сөрөг үр дагавар олон байдаг. Үүнд:

- хүний амь нас эрсдэх ба эрүүл мэндээр хохирч гэмтэх,
- эд хөрөнгө болон газар тариаланд эвдрэл сүйрэл тохиолдох,
- гол нэрийн бүтээгдэхүүн, амин чухал үйлчилгээнд доголдол бий болох,
- ажил төрөл, амьдралын баталгаа алдагдах,
- дэд бүтцэд хохирол учрах,
- төр засгийн хэвийн үйл ажиллагаа алдагдах,
- эдийн засгийн хохирол бий болох,
- нийгэм-сэтгэл зүйн сөрөг үр дагавар бий болох зэрэг байж болно.

Гамшгийг хамгийн бага хохиролтойгоор даван туулах, хохирлыг бууруулахад дан ганц гамшгаас хамгаалах салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагын оролцоотойгоор хэрэгжүүлэх боломжгүй гэдгийг дэлхий нийт хүлээн зөвшөөрч үүнийг бүх талын оролцоо улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах алба, түншлэлийн замаар хамтран хэрэгжүүлэхийг чухалчлах болсон.

Тамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ” баримт бичигт “Бүх салбар, холбогдох талуудын оролцоог хангаж, уур амьсгалын өөрчлөлт, түүний гамшгийн эрсдэлд үзүүлэх нөлөөллийг харгалзан гамшгийн бэлэн байдлын, онцгой байдлын үеийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулах, нягтлах, тогтмол шинэчлэх”-ийг тодорхойлон заасан.

1. Засгийн газрын бодлого, төлөвлөгөө, стандарт боловсруулах, хэрэгжүүлэхдээ эмэгтэйчүүд, хүүхэд, залуус, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ядуу иргэд, шилжин суурьшигсад, нутгийн уугуул иргэд, сайн дурынхан болон ахмадууд, холбогдох бусад талуудын оролцоог хангах хэрэгтэй.
2. Төр, хувийн хэвшлийн болон иргэний нийгмийн байгууллагууд, академи, шинжлэх ухаан, судалгааны байгууллагууд нягт хамтран ажиллаж, хамтын ажиллагааны шинэ боломжуудыг бий болгох, бизнесийн үйл ажиллагаандаа гамшгийн эрсдэлийг тооцдог байх шаардлагатай байна.
3. Суурь мэдээллийг сайжруулах, ашиглалтыг урамшуулах, гамшгийн эрсдэл, эмзэг байдал, чадавх, өртөх байдал, аюулын шинж чанарууд, тэдгээрийн экосистем, үндэсний нөхцөл байдалд нийгэм, орон зайн хүрээнд үзүүлж болзошгүй үр дагаврыг тогтмол үнэлэх
4. Эрсдэлийн зураглал зэрэг гамшгийн эрсдэлийн байршилтай холбоотой мэдээллийг боловсруулах, тогтмол шинэчлэх, шаардлагын дагуу шийдвэр гаргагчид, олон нийт, гамшгийн эрсдэлтэй ард иргэдэд гео-орон зайн мэдээллийн технологи ашиглан тохиромжтой хэлбэрээр хүргэх
5. Гамшгийн улмаас учирсан хохирлыг системтэй үнэлж, тэмдэглэх, олон нийтэд хүргэх, нийгэм, эдийн засаг, эрүүл мэнд, боловсрол, хүрээлэн буй орчин болон соёлын өвд үзүүлэх нөлөөллийг үйл явдал-тодорхой аюул-өртөх байдал эмзэг байдалтай холбон ойлгох
6. Аюулд өртөх байдал, эмзэг байдал, эрсдэл, гамшиг, хохирлын мэдээллийг олон нийт боломжийн хэрээр чөлөөтэй авдаг болох
7. Бодит мэдээллийг цаг тухайд нь авах боломжтой болгох, газар зүйн мэдээллийн систем, сансрын болон гамшгийн голомтын мэдээллийг ашиглах, хэмжих хэрэгсэл, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, түгээх боломжоо сайжруулахад мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг ашиглах
8. Бүх түвшний төрийн албан хаагчид, иргэний нийгэм, олон нийт, сайн дурынхан, хувийн хэвшлийнхний гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэгийг боловсрол, сургалтын механизмыг ашиглан

туршлага, сургамж, ололт амжилтаа харилцан солилцох, сургах замаар сайжруулах

9. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх, орон нутгийн онцлог нөхцөл байдал, бусад салбарын үйл ажиллагаанд нийцүүлэн тодорхой салбарын бодлого, стратеги, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд шинжлэх ухааны мэдлэгээс гадна уламжлалт арга ухаан, уугуул орон нутгийн мэдлэг, туршлагыг ашиглах

10. Байгаа мэдлэг, мэдээллийг нэгтгэх, ач холбогдлыг өсгөх, гамшгийн эрсдэл, аюулын төрөл бүрээр эмзэг байдал болон өртөх байдлыг үнэлэх аргачлал, загвар боловсруулах, ашиглахын тулд шинжлэх ухаан, техникийн чадавхийг бэхжүүлэх

Гамшгаас урьдчилан сэргийлэхэд зарцуулсан 1 доллар гамшгийн хор уршгийг арилгахад зарцуулах 7 доллартай тэнцэж байна гэсэн олон улсын жишиг тооцоо гарсан байдаг ба энэ нь гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулснаар үүсэж болох эрсдэлийг бууруулаад зогсохгүй хүний амь нас, эд хөрөнгийг хамгаалах чухал ач холбогдолтойг харуулж байна.

## ДҮГНЭЛТ

Монгол Улсад тохиолдож буй гамшгийн нөхцөл байдлыг дүгнэхэд аюулт үзэгдэл, ослын тоо хэмжээ байгаль, эклогийн өөрчлөлт, цаг агаарын дулаарал, техник, технологийн хөгжил дэвшил, хүний зарим зохиосгүй үйл ажиллагааны нөлөө, улсын хөгжил түүнийг дагасан хүн амын төвлөрөл, дэд бүтцийн ачаалал зэргээс шалтгаалан өсөн нэмэгдэж байна. Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийг хэрэгжүүлэхэд шат шатны байгууллага, аж ахуйн нэгжүүд анхаарах. Онцгой байдлын байгууллага эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүх төрлийн мэдээллийн хэрэгслийг ашиглан зохион байгуулж байгаа хэдий ч иргэдийн хандах хандлага өнөөгийн нийгмийн харилцаанаас шалтгаалан төдийлөн үр дүнд хүрэхгүй байна.

Гамшгийг хамгийн бага хохиролтойгоор даван туулах, хохирлыг бууруулахад дан ганц гамшгаас хамгаалах салбарт үйл

ажиллагаа явуулдаг төрийн байгууллагын оролцоотойгоор хэрэгжүүлэх боломжгүй гэдгийг дэлхий нийт хүлээн зөвшөөрч үүнийг бүх талын оролцоо түншлэлийн замаар хэрэгжүүлэхийг чухалчлах болсон.

## САНАЛ

Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсронгуй болгохын тулд санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх, ялангуяа сумдад урьдчилан сэргийлэх асуудал, хяналт хариуцсан мэргэжилтэн томилж ажиллуулах.

Гамшгаас хамгаалах чиглэлээр гарч буй төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэхэд шат шатны удирдлагууд, төрийн албан хаагчид, иргэдийн хандах хандлагыг өөрчлөх.